

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/240-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2023 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. Аудитын тайлан	18-21
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20-21
5. Аудитын илрүүлэлт	22-24
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	25-26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II бар
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН
СУМ ДУНДЫН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА, ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА
Б.АТАРБАЯР ТАНАА

2023.02.25 № С9А-2023/240-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Мандал сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн 1,658,593.3 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 100 хувьтай тайлагнагдсан байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Мандал сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 88.1 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд хангамж, бараа материалын зардалд 81,085.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой

тогтмол зардалд 57,040.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 33,131.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА


2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан



Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	79,611,945.68	114,952,024.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0	18,924,483.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0	18,924,483.00
31210	Төгрөг	0	18,924,483.00
31211	Төрийн сангийн харилцах	0	18,924,483.00
35	БАРАА МАТЕРИАЛ	79,611,945.68	96,027,541.68
35100	Түүхий эд материал	51,888,543.77	48,795,127.77
35110	Тусгай зориулалттай материал	51,212,043.77	48,176,127.77
35130	Эм боох материал	676,500.00	619,000.00
35400	Хангамжийн материал	19,929,621.91	37,035,037.91
35410	Бичиг хэргийн материал	3,458,440.00	9,161,120.00
35420	Аж ахуйн материал	7,501,533.00	16,198,575.00
35440	Түлш, шатах тослох материал	4,697,040.91	7,620,422.91
35460	Хүнсний материал	745,700.00	528,012.00
35470	Бусад хангамжийн материал	3,526,908.00	3,526,908.00
35600	Мал амьтад	7,793,780.00	10,197,376.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,266,830,382.64	1,167,412,753.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,266,830,382.64	1,167,412,753.81
39200	Биет хөрөнгө	1,100,003,715.96	1,000,467,753.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	760,231,456.50	760,231,456.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-75,130,598.88	-106,909,063.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	306,164,000.00	286,164,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-44,574,555.59	-75,488,888.91
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	155,468,942.73	187,498,616.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	-45,737,931.80	-95,641,173.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,697,943.89	30,137,943.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,732,445.89	-19,142,041.73
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	33,616,905.00	33,616,905.00
39300	Биет бус хөрөнгө	166,826,666.68	166,945,000.02
39301	Программ хангамж	800,000.00	1,240,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-133,333.32	-454,999.98
39303	Бусад биет бус хөрөнгө	166,160,000.00	166,160,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,346,442,328.32	1,282,364,778.49
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	416,237.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	416,237.00
41300	Өглөг	0	416,237.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	416,237.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,346,442,328.32	1,281,948,541.49
51	Засгийн газрын хувь оролцоо	1,346,442,328.32	1,281,948,541.49
51100	Засгийн газрын оруулсан капитал	595,746,480.28	595,746,480.28
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	595,746,480.28	595,746,480.28
51200	Хуримтлагдсан үр дүн	155,208,356.39	90,714,569.56
51210	Өмнөх үеийн үр дүн	110,272,524.36	155,208,356.39
51220	Тайлант үеийн үр дүн	44,935,832.03	-64,493,786.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	595,487,491.65	595,487,491.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,346,442,328.32	1,282,364,778.49

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан



Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,869,886,298.18	1,716,634,734.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	234,593,798.18	57,803,184.75
120	Нийтлэг татварын бус орлого	234,593,798.18	57,803,184.75
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	51,524,779.00	26,055,831.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,214,529.00	9,083,350.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	12,746,313.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	43,310,250.00	4,226,168.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	171,802,836.68	24,315,373.75
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	11,266,182.50	7,431,980.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,635,292,500.00	1,658,831,550.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,632,292,500.00	1,653,593,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,632,292,500.00	1,653,593,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,000,000.00	5,238,250.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	3,200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	2,038,250.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,824,950,466.15	1,781,128,521.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,824,950,466.15	1,781,128,521.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,815,317,917.15	1,773,580,101.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,425,307,400.00	1,432,154,719.00
210101	Үндсэн цалин	844,384,781.00	719,846,357.22
210102	Нэмэгдэл	580,922,619.00	712,308,361.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,003,400.00	30,301,369.10
210201	Тэтгэврийн даатгал	380,190.00	135,692.73
210202	Тэтгэмжийн даатгал	281,920.00	15,963.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	160,960.00	12,771.08
210204	Ажилгүйдлийн даатгал	190,960.00	3,192.77
210205	Эрүүл мэндийн даатгал	29,989,370.00	30,133,748.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,251,900.00	57,040,940.24
210301	Гэрэл, цахилгаан	15,306,696.00	13,708,777.90
210302	Түлш, халаалт	29,147,207.00	34,563,397.44
210303	Цэвэр, бохир ус	5,797,997.00	8,768,764.90
2104	Хангамж, бараа материалын зардал	84,387,769.68	85,733,618.32
210401	Бичиг хэрэг	6,188,520.00	10,823,900.00
210402	Тээвэр, шатахуун	56,895,633.68	53,619,318.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,843,667.00	6,003,023.32
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	275,000.00	515,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,456,850.00	9,850,745.00
210408	Бараа материал акталсны зардал	7,728,099.00	4,921,632.00
2105	Нормативт зардал	19,849,580.00	6,222,872.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,124,980.00	678,800.00
210502	Хоол, хүнс	18,474,300.00	5,544,072.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	250,300.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,525,600.00	12,655,640.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	439,500.00	364,900.00

210604	Урсгал засвар	24,086,100.00	12,290,740.00
2107	Томилолт, зочны зардал	4,178,000.00	4,865,770.00
210702	Дотоод албан томилолт	4,178,000.00	4,865,770.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,695,100.00	3,239,620.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	1,559,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	961,000.00	811,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	400,000.00	323,800.00
210807	Газрын төлбөр	100,000.00	251,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	234,100.00	293,920.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,119,167.47	141,365,552.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	3,038,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,558,414.80	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	168,560,752.67	138,327,302.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,632,549.00	7,548,420.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,580,000.00	3,444,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300,000.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,280,000.00	3,444,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,052,549.00	4,104,420.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,052,549.00	4,104,420.34
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	44,935,832.03	-64,493,786.83
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	44,935,832.03	-64,493,786.83

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан


 /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,643,507,029.00	1,689,053,383.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,214,529.00	30,221,833.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,214,529.00	30,221,833.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,214,529.00	30,221,833.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,214,529.00	9,083,350.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	21,138,483.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,635,292,500.00	1,658,831,550.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,632,292,500.00	1,653,593,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,632,292,500.00	1,653,593,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,000,000.00	5,238,250.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	3,200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	2,038,250.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,643,507,029.00	1,655,534,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,643,507,029.00	1,655,534,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,633,874,480.00	1,642,008,979.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,425,307,400.00	1,430,762,089.00
210101	Үндсэн цалин	803,982,762.00	845,111,157.42
210102	Нэмэгдэл	621,324,638.00	556,641,543.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	19,188,000.00
210104	Урамшуулал	0	9,821,388.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,003,400.00	30,460,402.10
210201	Тэтгэврийн даатгал	0	347,958.66
210202	Тэтгэмжийн даатгал	0	40,936.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	32,749.58
210204	Ажилгүйдлийн даатгал	0	8,187.39
210205	Эрүүл мэндийн даатгал	31,003,400.00	30,030,569.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,251,900.00	57,040,940.24
210301	Гэрэл, цахилгаан	15,306,696.00	13,708,777.90
210302	Түлш, халаалт	29,147,207.00	34,563,397.44
210303	Цэвэр, бохир ус	5,797,997.00	8,768,764.90
2104	Хангамж, бараа материалын зардал	67,450,800.00	81,085,598.32
210401	Бичиг хэрэг	6,502,100.00	14,044,300.00
210402	Тээвэр, шатахуун	52,143,700.00	53,528,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,843,667.00	6,003,023.32
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	275,000.00	515,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,686,333.00	6,994,475.00
2105	Нормативт зардал	19,650,280.00	5,384,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	299,980.00	742,800.00
210502	Хоол, хүнс	19,100,000.00	4,641,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	250,300.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,262,100.00	18,977,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	145,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.00	240,000.00
210604	Урсгал засвар	27,262,100.00	18,591,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,987,600.00	6,354,300.00

210702	Дотоод албан томилолт	2,987,600.00	6,354,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,461,000.00	4,689,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	3,060,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	961,000.00	1,054,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	400,000.00	323,800.00
210807	Газрын төлбөр	100,000.00	251,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,500,000.00	7,254,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	5,238,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	2,016,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,632,549.00	13,525,620.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,580,000.00	9,421,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300,000.00	4,833,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,280,000.00	4,587,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,052,549.00	4,104,420.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,052,549.00	4,104,420.34
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0	33,518,783.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	14,594,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	14,594,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	14,594,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	14,594,300.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	-14,594,300.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	18,924,483.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	18,924,483.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/


Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	595,746,480.28	595,487,491.65	110,272,524.36	1,301,506,496.29
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	595,746,480.28	595,487,491.65	110,272,524.36	1,301,506,496.29
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	44,935,832.03	44,935,832.03
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	595,746,480.28	595,487,491.65	155,208,356.39	1,346,442,328.32
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	595,746,480.28	595,487,491.65	155,208,356.39	1,346,442,328.32
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	595,746,480.28	595,487,491.65	155,208,356.39	1,346,442,328.32
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-64,493,786.83	-64,493,786.83
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	595,746,480.28	595,487,491.65	90,714,569.56	1,281,948,541.49

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан


/төгрөгөөр/
 АНУМТ
 АНУМТ
 АНУМТ
 АНУМТ
 АНУМТ

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,658,593,300.00	1,658,572,229.66	21,070.34	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,658,593,300.00	1,658,572,229.66	21,070.34	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,651,386,100.00	1,651,365,029.66	21,070.34	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,430,772,700.00	1,430,762,089.00	10,611.00	100.00
210101	Үндсэн цалин	848,122,800.00	845,111,157.42	3,011,642.58	99.64
210102	Нэмэгдэл	557,649,900.00	556,641,543.58	1,008,356.42	99.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,000,000.00	19,188,000.00	-4,188,000.00	127.92
210104	Урамшуулал	10,000,000.00	9,821,388.00	178,612.00	98.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,470,400.00	30,460,402.10	9,997.90	99.97
210201	Тэтгэврийн даатгал	0	347,958.66	-347,958.66	-
210202	Тэтгэмжийн даатгал	0	40,936.97	-40,936.97	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	32,749.58	-32,749.58	-
210204	Ажилгүйдлийн даатгал	0	8,187.39	-8,187.39	-
210205	Эрүүл мэндийн даатгал	30,470,400.00	30,030,569.50	439,830.50	98.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,041,400.00	57,040,940.24	459.76	100.00
210301	Гэрэл, цахилгаан	13,131,800.00	13,708,777.90	-576,977.90	104.39
210302	Түлш, халаалт	34,702,800.00	34,563,397.44	139,402.56	99.60
210303	Цэвэр, бохир ус	9,206,800.00	8,768,764.90	438,035.10	95.24
2104	Хангамж, бараа материалын зардал	81,085,600.00	81,085,598.32	1.68	100.00
210401	Бичиг хэрэг	14,123,000.00	14,044,300.00	78,700.00	99.44
210402	Тээвэр, шатахуун	53,528,800.00	53,528,800.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,058,600.00	6,003,023.32	55,576.68	99.08
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	534,300.00	515,000.00	19,300.00	96.39
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,840,900.00	6,994,475.00	-153,575.00	102.24
2105	Нормативт зардал	5,384,500.00	5,384,500.00	0.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	742,800.00	742,800.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	4,641,700.00	4,641,700.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,131,500.00	33,131,500.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,300,000.00	14,300,000.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	240,000.00	240,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	18,591,500.00	18,591,500.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	6,354,300.00	6,354,300.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	6,354,300.00	6,354,300.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,129,500.00	5,129,500.00	0.00	100.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,054,300.00	1,054,300.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	323,800.00	323,800.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	251,400.00	251,400.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,016,200.00	2,016,200.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,016,200.00	2,016,200.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,207,200.00	7,207,200.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,207,200.00	7,207,200.00	0.00	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,833,300.00	4,833,300.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,373,900.00	2,373,900.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,658,593,300.00	1,658,572,229.66	21,070.34	100.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,653,593,300.00	1,649,488,879.66	4,104,420.34	99.75
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,653,593,300.00	1,649,488,879.66	4,104,420.34	99.75
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	9,083,350.00	-4,083,350.00	181.67
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	9,083,350.00	-4,083,350.00	181.67
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	191	191	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	95	95	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	92	92	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	95	95	0.00	100.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	93	93	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2	2	0.00	100.00



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан



Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		5,238,250.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		5,238,250.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,238,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		5,238,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		5,238,250.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		5,238,250.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		5,238,250.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,038,250.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мандал сумын сум дундын Цагдаагийн хэлтэс /цаашид Мандал сумын Цагдаагийн хэлтэс гэх/ нь “Нийтийн хэв журмыг сахиулан хамгаалах, удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг үр чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж шуурхай байдлыг хангах” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх,
- Нийгмийн хэв журам сахиулах,
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах,
- Захиргааны хяналт тавих үүрэг гүйцэтгэх буюу хуулиар хүлээлгэсэн хуулийн биелэлтэд хяналт тавих.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Цагдаагийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 12 дугаар сарын 23-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 452 дугаар тогтоолоор Цагдаа, дотоодын цэргийн албан тушаалын цалингийн сүлжээг шинэчлэн тогтоосон,
- ЦЕГ-ын даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн А/205 дугаар тушаалаар Цалингийн зэрэглэл нэмэгдүүлэх, орон тоо, цолны зэрэглэлд өөрчлөлт оруулсан, 12 дугаар сарын 09-ны өдрийн А/327 дугаар тушаалаар цалингийн зэрэглэлд өөрчлөлт оруулсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Мандал сумын Цагдаагийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд ЦЕГ-ын Дотоод хяналт-аюулгүй байдлын газар хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын Цагдаагийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ЦЕГ-ын даргын 2013 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 422 дугаар тушаалаар Монгол Улсын цагдаа, дотоод цэргийн байгууллагын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын Цагдаагийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 64,077.5 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	18,924.5	18,924.5
Авлага	-	-	-
Бараа материал	79,611.9	96,027.5	16,415.6
Үндсэн хөрөнгө	1,266,830.4	1,167,412.8	(99,417.6)
Нийт хөрөнгө	1,346,442.3	1,282,364.8	(64,077.5)
Өр төлбөр	-	416.2	416.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,346,442.3	1,281,948.6	(64,493.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,346,442.3	1,282,364.8	(64,077.5)

Бараа материалын дансны үлдэгдэл 96,027.5 мянган төгрөг болж 16,415.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 106,200.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, ЦЕГ-аас 7,432.0 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авсан болон 96,521.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 7,793.8 мянган төгрөгийн мал амьтдыг нас дэвшүүлснээс голлон шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,465,048.9 мянган төгрөг болж, 18,909.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 14,594.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авсан, 24,315.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг ЦЕГ-аас шилжүүлэн авсан болон 20,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг аймгийн ОНӨГ-ын даргын 2021 оны 12 дугаар 31-ний 623 дугаар тушаалаар акталж, устгасантай холбоотой байна.

Тайлант онд ХХОАТ-ын 416.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,281,948.6 мянган төгрөг болж 64,493.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны нийт үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг /улсын төсвөөс/ 1,745,052.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 120,980.2 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 37,914.5 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг

22,205.4 мянган төгрөгөөр зэрэг нийт 184,858.0 мянган төгрөгөөр бууруулж, 1,560,194.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 98,398,9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн зохицуулалт хийсэн /цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 91,629.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 17,278.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 12,146.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нормативт зардлыг 15,015.5 мянган төгрөгөөр бууруулж баталсан нь голлон нөлөөлсөн/ байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,658,593.3 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,658,593.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,658,572.2 мянган төгрөг буюу 100.0 хувьтай байгаа нь “Цагдаа” хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардлыг 1.1 мянган төгрөгөөр, “Шүүгч болон гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах” хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардлыг 20.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
А	Цагдаа	1,549,052.1	1,549,051.0	1.1	100.00
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,541,844.9	1,541,843.8	1.1	100.00
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	7,207.2	7,207.2	-	100.00
Б	Шүүгч болон гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах	109,541.2	109,521.2	20.0	99.98
3	Үндсэн үйл ажиллагааны зардал	109,541.20	109,521.20	20.0	99.98
	Дүн	1,658,593.3	1,658,572.2	21.1	100.00

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130412403 тоот дансанд аймгийн Цагдаагийн газраас хорт ургамлын устгалын зардалд 3,200.0 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн даатгалын нөхөн төлбөрт 2,038.3 мянган төгрөг зэрэг нийт 5,238.3 мянган төгрөг шилжиж ирснийг зориулалтын дагуу зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мандал сумын Цагдаагийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримттай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын Цагдаагийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 44/2-121 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.


Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,824,950.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 18,249.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13,687.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албаны даргын 2022 оны 6/868 дугаар албан бичгээр цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга, захирагч нарт хүргүүлсэн “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн гарын авлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан ба 2022 оны 6/947 дугаар “Ажлын чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэхээс бусад чиглэлээр хөдөө, орон нутагт томилолтоор ажиллахыг зогсоосон,

- Баяр ёслол, тэмдэглэлт өдөр, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой контент, аялал зугаалга, уралдаан тэмцээн зохион байгуулаагүй,
- Ээлжийн амралтаар орон нутагт явах зардлыг олгоогүй ажилласан байна.



4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Мандал сумын Цагдаагийн хэлтсийн мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэл, цахим төлбөрийн баримт, анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой 18,846.4 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	18,846.4	4	11,361.7	80
Нийт дүн	5	18,846.4	4	11,361.7	80

/мянган төгрөгөөр/

Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Мандал сумын Цагдаагийн хэлтсийн төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. ЦЕГ-аас “Киа моторс-Монгол” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2021 онд үйлдвэрлэсэн, KIA Sportage /УАТ-1401 улсын дугаартай/ суудлын автомашиныг 2021 оны 8 дугаар сард хүлээн авсан бөгөөд ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албанаас “Автомашин нийлүүлэх санхүүгийн түрээсийн гэрээ”-ний дагуу төлбөрийг бүрэн төлж дуусаагүй учир автомашин нь улсын бүртгэлд нийлүүлэгч байгууллагын эзэмшилд бүртгэлтэй байна.

2. Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ЦЕГ-аас 2013 онд баталсан бөгөөд түүнд тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль эрхийн актын өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөн ажиллах шаардлагатай байна.

3. ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн албанаас 2022 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 14/1772 дугаар “Үүрэг, ажлын чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн 8 дугаарт “Төсвийн зардлын үлдэгдлээр байгууллагынхаа хэрэгцээнд шаардлагатай материалыг худалдан авах болон “Ахмадын сан”-д шилжүүлж, төсвийг бүрэн зарцуулах ажлыг зохион байгуулах” гэж холбогдох хууль, эрхийн актыг зөрчсөн үүрэг чиглэл өгсний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Жилийн эцэст төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлэлгүйгээр **5,275.0** мянган төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авч нөөцөлсөн,

- Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл **11,044.9** мянган төгрөгийг Сэ.Мандал Цагдаагийн хэлтэс Ахмадын сангийн харилцах 100130412508 дугаар дансанд шилжүүлсэн байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 7 дугаар зүйлийн 7.7 дахь “... төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд ... **төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ**”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4. ЦЕГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/336 дугаар тушаалын дагуу нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас 4,264.0 мянган төгрөг болон Санхүү, аж ахуйн албаны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 14/1772 дугаар албан бичгийн дагуу цалингийн хэмнэлт 11,044.9 мянган төгрөг зэрэг нийт тухайн жилийн төсөвт тусгагдаагүй 15,308.9 мянган төгрөгийг “Ахмадын сан”-ийн дансанд шилжүүлсэн байгаа нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах **хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана**”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд ахмадын санд төвлөрүүлэх хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгуулж батлуулсны үндсэн дээр санхүүжүүлэх шаардлагатай байна.

тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

4. Ээлжийн амралтын цалингийн бодолтод өмнөх онд эдэлсэн ээлжийн амралтын цалинг оруулан тооцсоноос 5 албан хаагчид нийт 3,075.6 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5: “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 3.4-д “Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл цалинг 2023 оны цалингаас нөхөн тооцож, суутгах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус хэлтсийн Мандал сумын Замын цагдаагийн пост, Хэрх тосгоны Цагдаагийн байр, Баянгол сумын Цагдаагийн хэсгийн байрны зарцуулсан 17 тонн буюу 1,212.5 мянган төгрөгийн нүүрсний зарцуулалтын тайланг гаргалгүйгээр шууд зардлаар бүртгэсэн байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Нүүрсний орлого, зарлагын тайланг тухай бүр гаргаж байх зөвлөмж өгөв.

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Анхан шатны баримтын бүрдлийг хангахгүйгээр **7,644.0** мянган төгрөгийн дараах ажил, гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:


- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр болон техникийн комиссын актгүйгээр машины засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд 7,644.0 мянган төгрөг,
- Эдэлгээ урттай, хуучин авто машины шатахуун зарцуулалтад ажиглалт хийж, норм, нормативыг шинэчлэн тогтоож, мөрдөөгүй, жолоочийн тооцооны хуудаст спидометрийн заалтыг зөрүүтэй бичдэг, албан хаагчид хувийн автомашиныг албаны хэрэгцээнд ашигласныг нотлох удирдамж, төлөвлөгөө нь бүрэн бус, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр "Жишиг норм батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм", 5 дугаар хавсралтаар баталсан "Автомашины сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм"-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгссөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				/мянган төгрөгөөр/	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Зөвлөмж			
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		/мянган төгрөгөөр/
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Ээлжийн амралтын цалинг зөрүүтэй тооцож олгосон.	1	3,075.6			1	3,075.6							
Үнэт цаасны үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй.	1	-			1	-							
ХХОАТ-ын өр төлбөр үүсгэсэн.	1	416.2			1	416.2							
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	2,465.7			1	2,465.7							

Нүүрсний зарцуулалтын тайлан гаргалгүйгээр шууд зардлаар бүртгэсэн.	1	1,212.5				1	1,212.5
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.	1	7,644.0				1	7,644.0
Дүн	6	14,814.0			4	5,957.5	8,856.5

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				Зөвлөмж
		Төлбөрийн акт		Албан шаардлага		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	8	-				8
Дүн	8	-				8
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн	8	-				8

4317445998
МЮА0065 9055436

Амжилттай
Хүндэтгэж
Хүндэтгэж
Хүндэтгэж